



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/256

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, 48.2.9 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төвхөн хийд, Хойд агуйт, Бөхөн шар, Өвтийн 20000 ширхэг хуш мод будах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Очирхуяг (Сум дундын Ойн ангийн дарга)

Гишүүд: Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)

Ш.Бумандолгор (Ойн инженер)

2.Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангуулж хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Д.Очирхуяг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

